



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 16 өдөр

Дугаар A/103

Хэрлэн сум

Сургалтын үйл ажиллагаанд
зохицуулалт хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.16 дахь заалт, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн A/52 дугаар тушаалыг тус тус үндэслэн

ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутаг дахь зуд, цаг агаарын хундрэлтэй нөхцөл байдал, томуугийн тархалттай холбогдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны A/244 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн жилийн бүтэц”-ийн 25 дахь долоо хоногийн “даваа” гараг буюу 2023 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн хичээлийг 2023 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн “бямба” гарагт, 2023 оны 2 дугаар сарын 24-ний өдрийн “баасан” гарагийн хичээлийг 2023 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн “бямба” гарагт тус тус шилжүүлж хичээл сургалтын үйл ажиллагааг зохицуулахыг Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга (С.Мөнхцэцэг)-д даалгасугай.

2. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын үйл ажиллагааг орон нутгийнхаа онцлогт тохируулан хүүхдийн аюулгүй байдлыг хангаж, ирсэн хүүхдийн тоог харгалзан багш, ажилчдын ажлын цагт зохицуулалт хийх зэргээр зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллахыг сумын Засаг дарга нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Өнөрцэцэг)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамжийг 2022-2023 оны хичээлийн жилд мөрдсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ



D:\My Documents\Захирамж 2023\231010294